



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 4/80

Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер
хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3, 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн багц-1 Гурил, гурилан бүтээгдэхүүн багцыг 23934200 (хорин гурван сая есөн зуун гучин дөрвөн мянга хоёр зуу) төгрөгөөр, багц-2 Сүү, сүүн бүтээгдэхүүн багцыг 21000000 (хорин нэгэн сая) төгрөгөөр, багц-4 Мах махан бүтээгдэхүүн багцыг 48381000 (дөчин найман сая гурван зуун наян нэгэн мянга) төгрөгөөр, багц-5 бусад бүтээгдэхүүн багцыг 19166300 (арван есөн сая нэг зуун жаран зургаан мянга гурван зуу) төгрөгөөр “Дэлгэрэх Хужирт” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Шалгарсан компанийтай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (А.Гантулга)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгохыг Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч (Ч.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй багц-3 Хүнсний ногоо багцыг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Чанцал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ



620100159